

**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРААС  
2020 ОНЫ 04 ДҮГЭЭР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2020 оны 05 дугаар сарын 04

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2020 оны 04 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

**НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР**

**1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:**

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 182 ширхгийг шинээр хэвлэн, 262 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 40 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын нэг иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 253 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 1237 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 793, 7585-1882 дугаарын утсаар 12, 7013-3459 дугаарын утсаар 11, биечлэн 63, автомат хариулагчаар 358 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн гадаадын нэг иргэн, өөрийн орны нэг иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



2020 оны 04 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 96.6 хувиар, виз олголт 97.4 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 96.9 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 42.5 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 50.5 хувиар, түр ирэгчийн бүртгэл 98.4 хувиар, түр ирэгчийн хасалт 94.7 хувиар, визийн сунгалт 79.0 хувиар тус тус буурсан байна.

Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан 03 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн хөдөлмөр эрхлэгч, хөрөнгө оруулагч гадаадын иргэдийн Монгол Улсад оршин суух зөвшөөрлийн сунгалтыг цахимаар авч эхэлсэн бөгөөд тайлангийн хугацаанд “Т” ангиллын 18 аж ахуйн нэгж, байгууллагын 26 гадаадын иргэн, “НГ” ангиллын 12 аж ахуйн нэгж, байгууллагын 21 гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгалаа.

Хилийн зарим боомтыг түр хаах, нэвтрэх хөдөлгөөнийг хязгаарлах тухай Засгийн газрын холбогдох тогтоол, шийдвэртэй холбогдуулан Монгол Улсын виз, визийн зөвшөөрөл олголт, Монгол Улсад түр ирэгч болон албан, хувийн хэргээр оршин суух гадаадын иргэний тус байгууллагаас авах үйлчилгээний тоо буурсан үзүүлэлттэй байна.


Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн таван удаагийн зарлигаар 78 иргэн гадаадын долоон улсын харьяат болохоор Монгол Улсын харьяатаас гарсан байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны Консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын нэг иргэний хүсэлтийг хүлээн авсан ба хуульд заасан шалгуурыг хангаагүй нэг улсын гурван иргэний хүсэлтийг буцаасан байна.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын хоёр улсын харьяат болох хүсэлт гаргасан найман иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, гадаадын зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 26 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна. Мөн гадаадын зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 33 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 37 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлэв.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй хоёр хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна. Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй таван хүний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлсэн.



Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн 65 иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба 2020 оны 04 дүгээр сарын байдлаар тус байгууллагын мэдээллийн санд хоёрдмол харьяалал үүсгэсэн 3648 иргэн бүртгэлтэй байна.

Тайлангийн хугацаанд салбар, төлөөлөгчийн газар шинээр нээн ажиллуулах нэг, үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан есөн олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан.

Мэргэжлийн зөвлөлийн хурлаар олон улсын болон гадаад улсын найман төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцэн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгалаа. 2020 оны 04 дүгээр сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 89 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.

Гадаадын нэг улсын гурван гэр бүлд үрчлүүлсэн гурван хүүхдийн үрчлэлтийн дараах тайланг хүлээн авч, мэдээллийн нэгдсэн санд бүртгэлээ.

#### 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:


Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн гадаадын нэг иргэнийг байгууллагын даргын нэг удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын гурван удаагийн тушаалаар гадаадын дөрвөн улсын долоон иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, нэг удаагийн тушаалаар гадаадын нэг иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Мөн байгууллагын даргын хоёр удаагийн тушаалаар гадаадын хоёр улсын дөрвөн иргэний Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг сунгасан.

Гадаадын иргэнийг зохих ангиллын визээр урьж, ажиллуулж байхыг анхааруулан 103 аж ахуйн нэгж байгууллагад хяналтын улсын байцаагчийн албан шаардлага өгсөн.

Тайлант хугацаанд нэг удаагийн төлөвлөгөөт, гурван удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 24 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 127 иргэнийг хамруулсан. Түүнчлэн 18 гадаадын иргэн, 39 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 227 иргэн/, нэг уригч иргэн /гадаадын нэг иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 69,920,000 /жаран есөн сая есөн зуун хорин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2020 оны 04 дүгээр сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан гадаадын иргэн 84.1 хувиар, зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 37.1 хувиар, зөрчил гаргасан уригч иргэн 66.7 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 97.1 хувиар тус тус буурсан, харин гарахыг түдгэлзүүлсэн гадаадын иргэн 75.0 хувиар өссөн байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу тус байгууллагад холбогдох хэсгийн тайлан, байгууллагын 2020 оны нэгдүгээр улирлын үйл ажиллагааны тайлан, 2020 оны 03 дугаар сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яаманд, байгууллагын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2020 оны төлөвлөгөө”-ний нэгдүгээр улирлын биелэлтийг нэгтгэн албан бичгээр Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд тус тус хүргүүлээ.

Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлээр өгсөн чиглэлийн дагуу Төрийн албаны зөвлөлөөс “Төрийн албаны тусгай шалгалт зохион байгуулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр сарын 13-ний өдрийн 141 дүгээр тогтоол гарч, хялбаршуулсан горимоор тусгай шалгалт зохион байгуулах аргачлалын дагуу ажиллалаа. Тус тогтоолын дагуу Төрийн албаны зөвлөлийн Гадаадын иргэн, харьяатын газрын дэргэдэх салбар зөвлөл хуралдаж, шалгалтын комиссыг таван албан тушаалтны бүрэлдэхүүнтэй байгуулсан.

Гүйцэтгэх есөн албан тушаалын сонгон шалгаруулалтын товыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулсан бөгөөд Захиргаа, удирдлагын газрын сургалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Өмнөд бүс дэх газрын Дундговь аймаг дахь ахлах мэргэжилтэн, Зүүн бүс дэх газрын мэргэжилтний албан тушаалын шаардлага, баримт бичгийн бүрдэл хангасан дөрвөн иргэнийг бүртгэж, шалгалтыг зохион байгууллаа.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу болзол хангасан төрийн захиргааны 14, төрийн үйлчилгээний 12 албан хаагчид таваас 25 хүртэл хувийн нэмэгдлийг байгууллагын даргын тушаалаар олгож эхэллээ. Мөн хоёр албан хаагчид зэрэг дэвийг шинээр, зургаан албан хаагчид зэрэг дэвийг ахиулан олгох саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлэв.

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед төрийн албан хаагчдын ээлжийн амралтыг хоёр, дөрөвдүгээр улиралд амрахаар зохицуулах тухай дээд газрын чиглэлийн дагуу байгууллагын төвийн нийт нэгжийн дарга, албан хаагчид болон орон нутаг дахь нэгжийн дарга нарын ээлжийн амралтын хуваарийг шинэчилж байгууллагын даргын тушаалаар батлан, мөрдөж байна.

Байгууллагын 2020 оны сургалтын төлөвлөгөө, байгууллагын даргын 2020 оны А/33 дугаар тушаалын дагуу хяналтын улсын байцаагчийн эрх олгох сургалтыг зохион байгуулсан.

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд ил тод мэдээлэх зорилгоор байгууллагын үйлчилгээтэй холбоотой мэдээлэл авах сувгуудыг танилцуулсан 37 секундний видео танилцуулгыг бэлтгэж олон нийтэд хүргэлээ. Мөн зөвлөгөө, мэдээллийн 1800-1882 дугаарын утсанд иргэдийн ирүүлсэн түгээмэл асуулт хариултуудыг нэгтгэж англи, монгол хэлээр дөрвөн цуврал мэдээлэл бэлтгэж хүргэв. Зарим төрлийн оршин суух үнэмлэхийг цахимаар сунгаж буй талаарх мэдээлэл “MNB World” сувгаар цацагдсан бөгөөд англи хэлээр нэвтлүүлсэн тус нэвтрүүлгийг байгууллагын цахим хуудас болон цахим сүлжээнд байршуулсан.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 63 өргөдөл ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 55 өргөдөл шийдвэрлэгдэж, найман өргөдөл шийдвэрлэлтийн шатандаа байна. Хугацаа хэтэрсэн өргөдөл, гомдол байхгүй.

Эрүүл мэндийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас ирүүлсэн 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 1а/13501 дугаар зөвлөмжийг зурагт санамж болгон бэлтгэж төв, орон нутаг дахь газар, хэлтэст хүргүүлэн, мэдээллийн самбарт байршуулан ажилласан. Мөн байгууллагаар үйлчлүүлсэн болон нэвтэрсэн иргэдийг бүртгэж, халууныг хэмжин шаардлагатай тохиолдолд асуумж авч, зөвлөгөө өгөн ажиллаж 04 дүгээр сард 1422 иргэн, нийт хугацаанд 4756 иргэд нэвтэрч бүртгүүлснээс биеийн дундаж температур 36.4°C байв.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон дагалдаж гарах хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцэх эсэх асуудлыг шийдвэрлүүлсэн ба Улсын Их Хурлын Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж байгууллагын даргын тушаалаар баталлаа. Байгууллагын үйл ажиллагаанд хамаарах хэрэглэгдэхээ больсон Засгийн газрын 2001 оны 71, 2011 оны 04 дүгээр тогтоолыг хүчингүй болгуулах Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг боловсрууллаа.

Тайлант хугацаанд 16 албан хаагчийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт хянуулахаар хүргүүлсэн. Мөн ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг давхардсан тоогоор 30 албан хаагч гаргасан байна.

Тайпэйн худалдаа, эдийн засгийн Улаанбаатар дахь төлөөлөгчийн газрын төлөөлөгч хатагтай Грэйс.Ж.Р.Лүө-тэй байгууллагын төлөөлөл уулзалт зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Гадаадын иргэнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэлтийн программ хангамжийн хөгжүүлэлтийг хийж байна. Мөн мэдээллийн самбарын программ хангамж хөгжүүлэх зураглалыг боловсруулан хянуулж, хөгжүүлэлт хийхэд бэлэн болсон.

Гадаадын иргэний цахим бүртгэлийн программ хангамжийн хөгжүүлэлтийн ажлын хүрээнд сервер дээр “Ubuntu” үйлдлийн систем суулгаж “Nginx”, “Uwsgi”, “Python”, “Django” зэрэг программуудын тохиргоо, “SSL certificate”-ийн тохиргоог хийж, домэйн хаягийг үүсгэн, сервер дээр өгөгдлийн санг суулган тохиргоог хийлээ. Хувилбар удирдах программын “Repositories”-д хандах эрхийг үүсгэн, өгөгдлийн сангийн бүтцийг боловсруулж батлууллаа.

### 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2020 онд 7.7 тэрбум төгрөг батлагдсан. 04 дүгээр сард 2 тэрбум 614.0 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 1 тэрбум 907.0 сая төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу энэ оны 04 дүгээр сарын байдлаар 510.7 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 274.1 сая төгрөгийн хүү торгуулийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлэн ажиллалаа.

2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 2020 оны Тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, Мэдээлэл, технологийн лиценз, Гадаадын иргэдийн цахим бүртгэл, Дүрэмт хувцасны тендерийг цахимаар зарлаж, сонгон шалгаруулалт хийгдэж, гэрээг байгуулсан.

Албан хаагчдын дотоод нөөц бололцоог дайчлан өрөө, тасалгаануудад урсгал засварын ажлыг хийж дуусгалаа.

### 2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын 2020 оны 03 дугаар сарын үндсэн үйл ажиллагааны мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Засгийн газрын Хэрэг эрхлэх

газар, Ерөнхий сайдын Ажлын албанд, Гадаадын иргэдийн бүртгэл, хяналтын 2020 оны 03 дугаар сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яаманд тус тус албан бичгээр хүргүүлсэн.

Тус байгууллагын 14 төсвийн шууд захирагч болон менежер нарын 2020 оны нэгдүгээр улирлын гүйцэтгэлийн тайланг үнэллээ.

Монгол Улсад зорчих гадаадын иргэн, харьяалалгүй хүнд виз, визийн зөвшөөрөл, оршин суух зөвшөөрөл олгох, сунгах, иргэний харьяалал, цагаачлал, гадаадын иргэн гэр бүлд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газартай холбоотой асуудлыг шийдвэрлэх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчлийг шийдвэрлэх үүргээ хэрэгжүүлсэн талаарх үйл ажиллагааны 2001-2019 оны тоон мэдээллийг эмхэтгэл хэлбэрээр бэлтгэн, хэвлэж холбогдох төрийн байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу төв, орон нутаг дахь нэгжүүдийн 2020 оны нэгдүгээр улирлын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт, шалгалт хийж, хяналт, шалгалтаар удаа дараа зөрчил гаргасан, дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй хоёр албан хаагчид арга хэмжээ авсан. Мөн байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу Агаарын замын боомт хариуцсан газрын 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулж байна.

Санхүү, хангалт, үйлчилгээний газрын үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах тухай зөвлөмж, хугацаатай үүрэг өгч ажиллалаа.

## 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу гадаадын нэг иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

“COVID-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх “Маскаа зүүцгээе” аян өрнүүлэх тухай Улсын онцгой комиссын 2020 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 9 дүгээр тогтоол, “Зорчигч тээврийн хөдөлгөөнийг хэсэгчлэн түр зогсоох тухай” мөн оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 10 дугаар тогтоолыг албан бичгээр хилийн боомт, орон нутаг дахь газруудад хүргүүлэн, хяналт тавин ажиллаж байна.

“COVID-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” Засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 дугаар тогтоолын дагуу 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хилийн боомтоор нэвтрэх зорчигчийн хөдөлгөөнийг түр зогсоосонтой холбогдуулан олон улсын тээвэр гүйцэтгэж байгаа гадаадын иргэн болон тусгай үүргийн нислэгээр ирсэн гадаадын иргэдэд хяналт тавьж ажиллав.